

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААС АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
НАРТАЙ 2019 ОНД БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

21 аймгийн Засаг дарга нартай 2019 онд байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **82.1** хувьтай. /хүснэгт-1/

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран
ажиллах гэрээний биелэлтэнд өгсөн үнэлгээ /2019 оны жилийн эцсийн байдлаар/

Хүснэгт 1

ДД	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувь				Дүгнээгүй	Биелэлт, хувь
					100	70	30	0		
1	Архангай	Ц.Мөнхнасан	1	21	9	4	1	4	3	67.2
2	Баян-Өлгий	А.Гылымхан	2	23	8	4	3	-	6	78
3	Баянхонгор	Г.Батжаргал	3	23	9	4	-	1	9	84.2
4	Булган	З.Батзориг	4	22	9	3	1	2	7	76
5	Говь-Алтай	С.Гансэлэм	5	21	9	1	4	2	4	68.1
6	Говьсүмбэр	Г.Батсуурь	6	22	17	1	1	-	3	94.7
7	Дархан-Уул	С.Насанбат	7	23	14	5	1	-	3	89
8	Дорноговь	Т.Энхтүвшин	8	22	15	5	-	-	2	92.5
9	Дорнод	М.Бадамсүрэн	9	22	12	5	1	-	4	86.1
10	Дундговь	О.Бат-Эрдэнэ	10	21	8	2	-	8	3	52.2
11	Завхан	Д.Батсайхан	11	21	6	6	2	-	7	77.1
12	Орхон	Д.Батлут	12	24	14	3	1	1	5	86.3
13	Өвөрхангай	Г.Ганболд	13	21	11	3	1	-	5	89.3
14	Өмнөговь	Н.Наранбаатар	14	23	13	7	1	1	1	82.7
15	Сүхбаатар	Ж.Эрдэнэбаатар	15	21	11	5	-	-	5	90.6
16	Сэлэнгэ	Ш.Оргил	16	21	11	2	2	-	6	86.6
17	Төв	Ж.Батжаргал	17	23	13	4	-	1	5	87.7
18	Увс	Д.Батсайхан	18	24	9	8	1	1	5	78.4
19	Ховд	Б.Дүгэржав	19	21	12	4	1	-	4	88.8
20	Хөвсгөл	Л.Ганболд	20	21	7	6	1	-	7	82.1
21	Хэнтий	Н.Ганбямба	21	21	9	3	1	-	8	87.6
НИЙТ										82.1

ДҮГНЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Зарим аймгууд хамтран ажиллах гэрээг тайлагнахдаа тухайн заалтад дурдсан арга хэмжээнд хамааралгүй арга хэмжээг тоочих, заалтын хүрээнд хийсэн ажлын хэмжээ харагдахгүй хэт ерөнхийлөн бичих, тухайн заалтын биелэлтийг өнгөрсөн цаг дээр болгож хуулбарлан бичих, аль суманд ямар аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй, бүрэн гүйцэд тайлагнаагүй, тодорхой тоо баримтыг дурдаагүй зэрэг зөрчлүүд илэрч байна. Тухайлбал, Өвөрхангай аймаг 3.2.21, Дундговь аймаг 3.2.8, 3.2.11, 3.2.16, 3.2.17, 3.2.18, 3.2.19, 3.2.20, 3.2.21 дэх заалтуудыг тайлагнаагүй мөн Булган аймаг гэрээний 3.2.10 дах заалтын биелэлтэд “Баяннуур сумын нутаг дах Цагаантолгойн боржин хэмээх газарт шил үйлдвэрлэх зориулалтаар хээрийн жоншны хайгуулын тусгай зөвшөөрлийг аймгийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/293 тоот захирамжаар олгосон ...” гэсэнийг шалгаж нягтах.

2. Архангай аймаг нь **“Уул уурхайгүй аймаг болж, хөдөө аж ахуйд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх”** хөгжлийн тэргүүлэх зорилт дэвшүүлэн ажиллаж байгаа тул энэхүү хамтран ажиллах гэрээний 3.2.9, 3.2.10, 3.2.11, 3.2.13, 3.2.15, 3.2.17-д заасан ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч, хүнд үйлдвэр, уул уурхайн боловсруулах үйлдвэртэй холбоотой 7 ажил үйлчилгээг хамааралгүй гэж тооцсон болно гэсэн тайлбар ирүүлсэн байна. Иймээс цаашид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас Архангай аймгийн Засаг даргатай 2020 онд гэрээ байгуулах эсэх, байгуулбал ямар чиглэлэр хамтран ажиллах талаар тодруулах.

3. Ихэнх аймгуудад гэрээний дараах заалтууд болон тус заалтуудын зарим хэсэг хэрэгжээгүй байна. Тодруулбал, 3.2.9-д: “Орон нутагт газар олголтыг зохион байгуулахдаа хүнд үйлдвэр байгуулах боломжит байршлыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газар олгох, шаардлагатай тохиолдолд газрыг тусгай хэрэгцээнд авах асуудлаар холбогдох хууль журмын хүрээнд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах”, 3.2.17-д: “ Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, холбогдох газар нэгж, агентлаг болон геологи, уул уурхай, газрын тос, хүнд үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлсэн 2018 оны 04, 05, 06 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллах”, Орон нутагт боловсруулах үйлдвэр байгуулах болон түүнтэй холбоотой дэд бүтцийн бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлэхээр ажиллаж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хууль, журмын хүрээнд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах; 3.2.20-д: “Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулах үйлдвэрүүдийн ерөнхий мэдээллийг хагас жил тутам буюу тухайн жилийн 07 дугаар болон 12 дугаар сарын эхний хагаст багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх”, 3.2.21-д : “Орон нутгийн онцлог, давуу талд тулгуурласан эдийн засаг нийгэмд бодит хувь нэмэр оруулах, боловсруулах үйлдвэр байгуулах боломжийн талаар

судалгаанд суурилсан санал боловсруулж, II улиралд багтаан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд ирүүлэх” гэсэн заалтууд тус тус хамаарч байна.

4. Гэрээний 3.2.1, 3.2.4 дэх заалтад хамрагдсан Улсын төсвийн хөрөнгөөр тухайн орон нутагт хэрэгжүүлж байгаа 1:50000-ны масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн Олонгол-50, Бүрхтэй уул-50 төслийг хэрэгжүүлэх явцад Архангай аймгийн Цэцэрлэг сум, Дорноговь аймгийн Өргөн сумын иргэд, малчид удаа дараа саад учруулж, орон нутагт мэдэгдсэн боловч арга хэмжээ авахгүй байгаа нь уг төслүүдийн ажлын гүйцэтгэлийг удаашруулж байна.

Дорнод аймгийн Засаг даргаас ирүүлсэн гэрээний биелэлтийг дүгнэхэд 3.2.4, 3.2.8, 3.2.12 дах заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүйн улмаас Дорнод аймгийн Чойбалсан, Матад сумдын нутагт улсын тусгай хэрэгцээнд авсан газрын тосны хайгуулын Баянтүмэн XVII, Матад XX талбайнуудад газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар Засгийн газартай Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Магнай Трейд” ХХК болон “Петро Матад” ХХК нарын үйл ажиллагаанд орон нутгаас дэмжээгүй бөгөөд тухайн хайгуул хийхээр төлөвлөн ажиллаж байсан газрыг чөлөөлөх тухай мэдэгдлийг Дорнод аймгийн Засаг даргын 2019.07.29-ний өдрийн 1/1593 дугаар албан бичгээр тус яаманд ирүүлсэн. Энэхүү мэдэгдэл нь тухайн онд газрын тосны хайгуул хийхээр төсөв, төлөвлөгөө батлуулсан аж ахуйн нэгжүүдэд Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хүндрэл учирж байна.


САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. Тухайн аймагт геологи, хайгуул болон газрын тос, хүнд үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг харгалзан үзэж хамтран ажиллах гэрээг байгуулах;
2. Аймгууд хамтран ажиллах гэрээний биелэлтэд ач холбогдол өгч, гэрээний заалт бүрээр хийсэн ажил, биелэлтийг оновчтой, тодорхой, хэрэгжүүлсэн субъект, албан бичиг хүргүүсэн огноо, дугаартайгаар үнэн зөв гаргаж хэвших.
3. Гэрээний заалтад хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах
4. Тухайн зорилт, арга хэмжээний гол үр дүн, хүрсэн түвшин, төлөвлөсөн асуудалтай уялдуулж ажлаа тайлагнах тал дээр анхаарч ажиллах.
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас боловсруулан батлуулсан бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан чиглэл, хэрэгжүүлэх бүсчлэлийг харгалзан аймаг тус бүрт ажил, арга хэмжээнүүдийг ялгавартай тусгах.
6. Гэрээнд тухайн бүс нутагт хэрэгжих боломжгүй олон ажлыг тусгахгүйгээр зөвхөн чанартай тухайн орон нутагт хэрэгжүүлэх шаардлагатай, хэрэгжүүлэх боломжтой бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан ажлуудаа цөөхөн заалтаар оруулах

7. Уул уурхайн салбар нь улсын төсвийн голлох хэсгийг бүрдүүлдэг тул хамтран ажиллах гэрээг байгуулахдаа дээр дурдсан алдаа дутагдлыг дахин гаргуулахгүй байхад анхаарах, яамны нэгжүүд болон Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас гэрээний төсөлд өгсөн саналыг тусгах зэрэг асуудалд Стратеги, бодлого төлөвлөлтийн газар, Төрийн захиргааны удирдлагын газар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

ТАНИЛЦСАН:
ХШУДАГ-ЫН ДАРГА


Г.ГАНХҮҮ

БОЛОВСРУУЛСАН:
ХШУДАГ-ЫН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  Д.БОЛОРТУЯА

2020 оны 01 дүгээр сарын 02